Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Төсөл хөтөлбөрийн хяналт шинжилгээ, үнэлгээ, нэгдсэн тайлагналт хариуцсан ахлах мэргэжилтэн, Цэвэгмид Нямсүрэн

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, тайлагнах.							
1	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, тайлагнах.	Зорилтын тоо, шалгуур	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн 2022 оны жилийн эцсийн тайлан	-	Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлж буй гадаадын зээлийн 5, буцалтгүй тусламжийн 2 төсөл, нийт 7 төсөл байна. Хэрэгжиж буй төслүүдийн тайлангийн зорилтын дундаж үнэлгээ 78.5 хувийн биелэлтэй, нийт төслийн нэгжүүдийн хэрэгжсэн хугацааны тайлангийн үнэлгээг хэрэгжих хугацаанд харьцуулбал 61.4 хувь, төслийн тухайн жилийн ашиглалт 65.8 хувьтай байна. Харин 2022 оны нийт төслүүдийн бүрэлдэхүүн хэсгийн хэрэгжилттэй харьцуулахад 0.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	2-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 70% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					Мөн 2024 оны 10 дугаар сард нийт төсөл 23 үүнээс зээлийн төсөл 4, буцалтгүй тусламж 19 төслийн мэдээллийн хэрэгжилтийг нэгтгэж ЗГХЭГ-т явуулсан. Хууль тогтоомжийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4-д заасан шаардлагын дагуу гадаад болон монгол хэл дээр хийсэн гэрээ, тайланг ODAMIS-д байршуулснаас мэдээллийг авсан. Монгол Улсын Засгийн Газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2024 оны 8 дугаар сарын 29-ний өдөр ирүүлсэн "Зөвлөмж хүргүүлэх тухай" 01/621 дугаартай албан бичгээр гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн төслийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн гаргасан зөвлөмжийг ирүүлсэн. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжсэн төслийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үндэслэн 2024 оны үйл ажиллагааг үр дүнг нэмэгдүүлэхийн тулд өгсөн зөвлөмжийн хүрээнд арга хэмжээг хэрэгжүүлэн авч ажиллаж байна. Боловсролын яаманд хэрэгжиж буй гадаадын зээл 3, хөнгөлттэй зээл 1, техник		

					туслалцааны 1, хүмүүнлэгийн 2, тусламжийн төсөл 16, нийт 23 төсөлт хөтөлбөр хэрэгжиж байна. Зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх ажлыг яамны холбогдох нэгж болон хариуцсан албан хаагч бүрээс цуглуулсан мэдээ, мэдээлэлд үндэслэн биелэлтийг ханган ажиллаж байна. / Төслүүдийн хэрэгжилтийг хавсаргав./ Хавсралт: 2 файл		
1.2. Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалт, төсөв, мэдээллийн нэгдсэн тогтолцоо, аюулгүй байдал, харьяа байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан дотоод аудит явуулах, дүгнэлт, зөвлөмж гаргах							
2	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих үйл ажиллагаа, гүйцэтгэл, үр дүнд хяналт-шинжилгээ, дотоод аудит хийх	Үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүн	2023 оны үйл ажиллагааны тайлан	-	Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга, Их хурлын гишүүн Б.Баярсайхан ахалж, гишүүдээр Улсын Их, Боловсрол, шинжлэх ухааны яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээний ахлах мэргэжилтэн Ц.Нямсүрэн, ерөнхий газрын Хөрөнгө оруулалтын газрын Захиалагчийн хэлтсийн мэргэжилтэн С.Билэгбаатар Боловсролын ерөнхий газрын Хөрөнгө оруулалтын газрын Захиалагчийн хэлтсийн дарга Н.Амарбаяр, Боловсролын, Барилгын хөгжлийн төвийн Барилга	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					байгууламжийн Захиалагчийн хэлтсийн дарга Э.Мөнхсүх, Барилгын хөгжлийн төвийн хяналтын инженер н.Ганпүрэв, Төрийн өмчийн сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн ариун цэврийн байгууламжаар солих төслийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх бүрэлдэхүүнд төслийг хариуцан хэрэгжүүлэх, хяналт хийх үүрэг чиглэл бүхий байгууллагын хариуцсан албан хаагчдыг тус тус оролцуулсан.Ажлын хэсгийн бүрэлдэхүүн хяналт шалгалтыг 2024 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөс 04 дүгээр сарын 11-ний өдрийг дууссалх хугацаанд буюу нийт 12 хоногт хийж гүйцэтгэлээ.Хяналт шалгалтад ХОВД аймгийн 15 сумын 55 объектыг хяналт, шалгалтад хамрагдсан. Хавсралт: 1 файл		
3	“Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүн	-	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан байна.	Энэ удаагийн хяналт-шинжилгээ үнэлгээгээр Ерөнхий боловсролын сургуулийн “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөр сургуулийн сургалт, үйл ажиллагаанд хэрхэн хэрэгжиж байгаа,	9-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн

					мөн хэрэгжилтэд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар мэдээлэл цуглуулах, холбогдох баримт бичигт шинжилгээ хийх, сургалтын байгууллагын удирдах ажилтнаас ярилцлага, багш, сурагчдаас асуулга судалгаа авч, суралцагчийн мэдлэг, чадвар, сургуулийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх сургалт, үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийлээ. Нийслэл, орон нутгийн төрийн өмчийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулиудаас санамсаргүй түүврийн аргыг ашиглан 21 аймаг 9 дүүргийн ерөнхий боловсролын нийт 30 сургуулийг санамсаргүй түүврээр сонгон мэдээлэл цуглуулав. Судалгаанд ерөнхий боловсролын 30 сургууль, 87 сургалтын менежер, нийгмийн ажилтан, 902 багш, бага, дунд, ахлах ангийн 1828 суралцагчдыг хамруулав. Мэдээллийг цуглуулахад 72 мэргэжилтэн 2024 оны 09 дүгээр сарын 12-оос 16 хооронд ажилласан. Үүнд: • Боловсролын яам • Боловсролын ерөнхий газар • Онцгой байдлын ерөнхий газар •		даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн • Боловсролын газар • Онцгой байдлын газрын ажилтан албан хаагчид, мэргэжилтнүүд тус тус оролцсон болно.Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, сургалтын байгууллагын орчин, хэрэглэгдэхүүн, үнэлгээний нөхцөл байдал • Ерөнхий боловсролын сургуулиудад гадаад, дотоод орчны эрсдэлийн үнэлгээг захирлын тушаалаар баталж, ажлын хэсэг үнэлгээ хийсэн байна. Ажлын хэсэгт эцэг, эх, сурагчдын төлөөллийг оролцуулан улирал бүр үнэлгээ хийж, зөрчлийг арилгах арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулж байгаа нь үр дүнтэй байна. • Сургуулийн тавилга, эд хогшил, үзүүлэн самбар, хүндэтгэлийн булан зэргийг хананд бэхэлгээ хийж байрлуулах, цахилгааны утсанд гадны хүчин зүйл үйлчилж гэмтэл үүсэх эрсдэлтэй тохиолдолууд их байна. Хавсралт: 2 файл		
1.3. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх							

4	Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төслийн нэгжийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлийн чанар, үр дүн	2023 оны үйл ажиллагааны тайлан	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитыг хийж, нэгдсэн дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан байна.	Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төслийн нэгжийн 2023,2024 оны эхний хагас жилийн нэгжийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан дотоод аудит хийж, дүгнэлт зөвлөмж гаргана. Боловсролын сайдын 2024 оны 11 дугаар сарын 25-ны А/207 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэг орж ажиллана. Хавсралт: 2 файл	10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субьект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Холбогдох хууль, дүрэм журмыг уншиж судлах	Ажлын чиг үүргийн хүрээнд холбогдох хууль, дүрэм журмыг уншиж судална.	-	Холбогдох хууль, дүрэм журмыг уншиж судалсан байна.	Ажлын байран дахь тасралтгүй хөгжлийг хангах үүднээс дээд шатны байгууллага, Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас зохион байгуулсан сургалт, яамны мэдээллийн цагаар явагддаг	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар,	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын

					сургалтуудад тогтмол хамрагддаг. Мөн 8 дугаар сард Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас зохион байгуулсан "Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хяналт-үнэлгээ хийх" сэдэвт сургалтад хамрагдаж, холбогдох мэдээллийг нэгжийн даргад танилцуулсан.Ажил үүргээ гүйцэтгэх явцад шаардагадах хууль, дүрмүүдийг уншиж судалсан.Ажлын албан хэрэгцээнд ""Багшийн гурван тулгуурт бодлого" цогц арга хэмжээ"-г уншиж судалсан.	11-р сар, 12-р сар	үнэлгээ: 90%
2	Ажлын чиг үүргийн хүрээнд холбогдох сургалтад хамрагдах	Удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу холбогдох сургалтад хамрагдах	-	Сургалтад хамрагдсан байна.	Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан "Гүйцэтгэлийн удирдлага", “Төрийн жинхэнэ албан хаагчийг томилох үйл ажиллагаанд тавих хяналт", "Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа" зэрэг сэдэвт сургалтад хамрагдсан. "Монгол Улсын Хөгжлийн бодлого үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл" 2 өдрийн сургалт /Удирдлагын академи/ ,2024 оны 11 дүгээр сард Удирдлагын академаас зохион байгуулсан "Төрийн албаны удирдах албан тушаалтны ур чадварыг хөгжүүлэх нь” сэдэвт сургалтад хамрагдаж сертификат авсан. 1. Мэдээллийн цагийн хуваарийн дагуу 2024.03.26-ны өдөр зохион байгуулсан "21 дүгээр зууны боловсрол-Насан туршийн суралцахуй" сэдэвт мэдээлэллийн цагт хамрагдсан. 2. Мэдээллийн цагийн хуваарийн дагуу 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулсан Нура төвийн их эмч С.Цэрэнпагма "Витаминны хэрэглээ болон багц оношилгооны талаар"	4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90%

					сэдэвт мэдээллийн цагт хамрагдсан. 3. Мэдээллийн цагийн хуваарийн дагуу 2024.05.22-ны өдөр зохион байгуулсан Философийн хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга М. Анара (Ph.D) "Албан хаагчийн сэтгэл зүйн эрүүл мэндийн үндэс: стресс менежмент" сэдэвт мэдээллийн цагт хамрагдсан. 4. Мэдээллийн цагийн хуваарийн дагуу дараах сургалтад хамрагдсан. "Үндэсний бичгийн анхан, дунд, ахисан түвшний сургалт", "Хөгжил ба мэдлэг" "Боловсролын салбарын 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөлөл", "Боловсролын яамны албан хэрэг хөтлөлтийн журмын тухай баримт бичгийн боловсруулалтын явц" 4. Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 сургалтад бүрэн хамрагдсан. Хавсралт: 3 файл		

ТАЙЛАН ГАРГАСАН:

Төсөл хөтөлбөрийн хяналт шинжилгээ, үнэлгээ, нэгдсэн тайлагналт хариуцсан ахлах мэргэжилтэн, Цэвэгмид Нямсүрэн

/...../ Огноо: .....